рЗасгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Олон улсын худалдааны бодлого, төлөв байдлын судалгаа хариуцсан шинжээч, Мөнхбаатар Дөл-Эрдэнэ

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих; | | | | | | | |
| 1 | Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч салбар хоорондын уялдааг хангана. | Хэрэгжилтийн явц /Хувь/ | Өндөр, дээд түвшний нийт 45 уулзалт, ТНБД, газрын дарга нарын түвшинд 59 уулзалт зохион байгуулсан. Түнш улс орон, олон улсын байгууллагатай хөгжүүлсэн харилцаа, хамтын ажиллагааны мэдээллийн сан, бүрдүүлэн тухай бүр шинэчилж ашигласан. | Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | Тайлант хугацаанд нийт өндөр дээд түвшний 11 уулзалт, техникийн түвшний 14 уулзалтыг зохион байгуулж, ярианы сэдвийг боловсруулсан холбогдох бэлэн байдлыг хангаж ажилласан. | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлох, импортыг | Хэрэгжилтийн явц /Хувь/ | Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, худалдааны тэнцлийг сайжруулахад | Тухай бүр судалгаа хийж, санал боловсруулж, холбогдох арга | 1) Монгол Улсаас бусад улс оронтой байгуулсан худалдааны болон эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавина. | | чиглэсэн бодлого боловсруулж нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж ажилласан. Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж батлуулсан. | хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | заасан хөнгөлөлтийг үндэсний үйлдвэрлэгчид ашиглах боломжийг нэмэгдүүлж, уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортлох, импортлох иргэн, аж ахуйн нэгжээс гаргасан хүсэлтийг шийдвэрлүүлэх, "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой Засгийн газрын 2025 оны 51 дүгээр тогтоолыг батлуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажилласан. 2) Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн дагуу 2027 оны 6 дугаар сард багтаан Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бүрэн нэвтрүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд одоогийн байдлаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хилийн дэд бүтцийн болон мэдээллийн систем | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэвтрүүлэх ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд холбогдох судалгаа, мэдээллийг боловсруулж дэмжлэг үзүүлж ажилласан. 3) Мал, малын чанарыг дээшлүүлэх, олон улсын стандартад нийцсэн малын вакциныг дотооддоо үйлдвэрлэх, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг дэмжих хүрээнд "Ногоон өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй" төслийн материалыг судалж, санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор тус яамны 2025 оны 01/1047 тоот албан бичгийг ХХААХҮЯ-нд, 01/1374 тоот албан бичгийг Дэлхийн банканд тус тус хүргүүлсэн. | | |
| 3 | Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авах, хэрэгжилтэд хяналт тавина. | Хэрэгжилтийн явц /Хувь/ | Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн ба Ази номхон далайн худалдааны хэлэлцээр, Ази номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр, Европын | Тухай бүр судалгаа хийн дүгнэлт гаргаж, санал боловсруулан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | Монгол Улс, Япон Улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдөр МҮХАҮТ-д хамтран | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбооны хөнгөлөлтийн ерөнхий системд тус тус нэгдэн орсон байх ба Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан. | | зохион байгуулсан 4 дэх удаагийн "Монгол-Японы бизнес, инновацын форум"-ын үеэр тус яамнаас тавигдсан илтгэл, хэлэх үгт эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг Монголын ААН-үүд ашиглаж буй байдал, Япон Улсаас Монгол Улсад хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдааны статистикт анализ хийж холбогдох мэдээллийг боловсруулсан. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зөвлөлдөх уулзалт"-ын үеэрх Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн дэд сайд Кенжи Ямадатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт дээрх чиглэлд санал боловсруулж, ярианы сэдэвт тусгасан | | |
| 4 | Цаг үеийн шинж чанартай удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр гүйцэтгэнэ. | Хэрэгжилтийн явц хувиар | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр гүйцэтгэнэ. | Тухай бүр тайлагнасан байна./100 хувь/ | БНХАУ, БНСУ, ОХУ-ын Эрхүү хотод зохион байгуулагдсан форумын бэлтгэл ажлыг хангаж,холбогдох уулзалтуудын ярианы сэдвийг боловсруулхад | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжлэг үзүүлж ажилласан. | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна/100 хувь/ | 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгээс хийсэн "Бүсчилсэн хөгжлийн бодлого, гадаад худалдааны хамаарал" сэдэвт сургалтад хамрагдсан. | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна. | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна/100 хувь/ | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт идэвхитэй хамрагдсан. | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ХЯНАСАН:

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Даринчулуун Эрдэнэтуяа /........................................................./
Огноо: .........................

ТУ32861 6806236 9022010236

ТАЙЛАН ГАРГАСАН:

Олон улсын худалдааны бодлого, төлөв байдлын судалгаа хариуцсан шинжээч, Мөнхбаатар Дөл-Эрдэнэ

/.................................................../ Огноо: 2025.12.15.